



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/65

Чойр

«Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний
дуудлага худалдааны анхны үнэ тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь хэсэг, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны “Аргачлал шинэчлэн батлах тухай” 15 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Говьсүмбэр аймгийн хот тосгон, бусад суурин газрын газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг 1 дүгээр хавсралтаар, тариалангийн газрын газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг 2 дугаар хавсралтаар, төвийн сумын дуудлага худалдааны бүсийн хил хязгаарыг харуулсан зургийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү захирамжийн хавсралтуудыг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах газрын газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг тогтоож, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/123 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА

Г.БАТСУУРЬ



Аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар захирамжийн хавсралт

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХОТ ТОСГОН БУСАД СУУРИНЫ ГАЗАРТ
ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ



№	Сумын нэр	Үнэлгээний бүс	Анхны үнэ /эзэмших, ашиглах газрын зориулалт/											
			Бүх мөрлийн орон сууц	Иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар /хашаа байшин барих, амины орон сууц	Худалдаа бүх төрлийн үйлчилгээ /төг/	Аж ахуйн үйл ажиллагаа /худалдаа үйлчилгээнээс бусад/	Нефтийн бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц /төг/	Бүх төрлийн тээврийн гараж, тээврийн хэрэгслийн зогсоол, газар дээрх дараах/	Дулаан холбоо, эрчим хүчний станц, антенн/төг/	Төмөр зам, нисэх онгоцны буудлын барилга байгууламж	Нам, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төлөөлөгчийн газар/төг/	Шашин сүм хийд /төг/	ХАА-аас бусад үйлдвэрлэл /төг/	ХАА- н үйлдвэрлэл/төг/
1	Сүмбэр	1-р бүс	1000	1600	4000	3000	2400	4000	1000	600	4000	6000	4000	-
		2-р бүс	1000	1200	2000	2000	2000	3000	800	600	3000	4000	2000	-
		3-р бүс	600	1000	1800	1000	2000	1800	600	400	2000	2000	1000	600
		4-р бүс	600	600	1400	1000	1000	1000	200	200	1000	1400	600	200
		5-р бүс	600	600	1000	600	600	600	200	200	1000	1000	200	200
2	Баянтал, Шивээговь	1-р бүс	200	320	480	480	480	400	200	120	400	400	400	-
		2-р бүс	200	320	480	480	400	400	200	120	400	400	280	-
		3-р бүс	200	320	400	400	400	360	200	80	360	360	200	160
		4-р бүс	120	280	360	360	200	320	120	40	360	280	120	80
		5-р бүс	120	280	320	280	120	240	80	40	280	280	80	40

03 дугаар сарын 08 ны өдрийн 08 дугаар захирамжийн 2 хавсралт



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ТАРИАЛАНГИЙН ГАЗРЫН
ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ

№	Сумдын нэр	Зэрэглэл	1 га тариалангийн газрын эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ	
			Үр тариа, тэжээлийн ургамал тариалах	Төмс, хүнсний ногоо, бусад ургамал тариалах
1	Сүмбэр	III	8690	31284
2	Баянтал	II	17380	43450
3	Шивээговь	II	17380	43450

000

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ТӨВИЙН СУМЫН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ БҮСИЙН ЗУРАГ

Аймгийн Засаг даргын 2009 оны
05 сарын 14-ны өдрийн 14 дугаар
захиармжийн 5 хэсгээр



Таних тэмдэг

- Суурин
- Үнэлгээний бүс
- 1-р бүс
- 2-р бүс
- 3-р бүс
- 4-р бүс
- 5-р бүс